

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 5 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан тушаалтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Дамдингийн Энхтуяад дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Завхан аймгийн Засаг даргаар ажиллаж байсан П.Гансүхийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>2004-2008 онд Завхан аймгийн Засаг даргаар сонгогдон ажиллаж байсан Пүрэвжавын Гансүхийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн</p>

		<p>жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Өвөрхангай аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Өвөрхангай аймагт 2014 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 46 иргэнээс 33 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 13 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 12 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 5 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан нэр бүхий</p>

		<p>17 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Төрийн албаны мэргэшлийн шалгалтад бүртгүүлэхгүй байгаа төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны судалгаа	<p>Төрийн албаны мэргэшлийн шалгалтад бүртгүүлэхгүй байгаа төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байранд хийсэн судалгааны үндсэн дээр эдгээр сул орон тоог хэрхэн, яаж нөхөх арга замыг судлах хамтарсан Ажлын хэсэг байгуулах саналаа, судалгааны хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.</p>
5	Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журмыг боловсронгуй болгох саналын тухай	<p>1. Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн уялдааг хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэхтэй холбогдсон саналыг судалгааны явцад ирүүлсэн материалын хамт Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсэгт уламжлах.</p> <p>2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг боловсронгуй болгох Ажлын хэсэг байгуулж, Ажлын хэсэг боловсруулсан саналын төслөө 2014 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ТАЗ-ийн хуралдаанд танилцуулах</p> <p>3. Төрийн жинхэнэ албан</p>

		хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг боловсронгуй болгох Ажлын хэсэг Ажлын хэсэгт менежментийн онолын багш судлаачдыг оролцуулбал цалин хөлсийг журмын дагуу олгох асуудлыг судлах нь зүйтэй гэж үзэв.
6	Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлүүдийн 2013 оны үйл ажиллагааны тайлангийн дүнгийн тухай	<p>1. Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн уялдааг хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэхтэй холбогдсон саналыг судалгааны явцад ирүүлсэн материалын хамт Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсэгт уламжлах.</p> <p>2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг боловсронгуй болгох Ажлын хэсэг байгуулж, Ажлын хэсэг боловсруулсан саналын төслөө 2014 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ТАЗ-ийн хуралдаанд танилцуулах</p> <p>3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг боловсронгуй болгох Ажлын хэсэг Ажлын хэсэгт менежментийн онолын багш судлаачдыг оролцуулбал цалин хөлсийг журмын дагуу олгох асуудлыг судлах нь зүйтэй гэж үзэв.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

